



Title	Зах зээлийн эдийн засагт шилжсэний дараа байгалийн гамшиг, нийгмийн асуудлыг шийдвэрлэх малчидын философи ба хамтлага
Author(s)	Имаока, Риоко
Citation	大阪外国語大学論集. 2003, 28, p. 1-12
Version Type	VoR
URL	https://hdl.handle.net/11094/79900
rights	
Note	

The University of Osaka Institutional Knowledge Archive : OUKA

<https://ir.library.osaka-u.ac.jp/>

The University of Osaka

Зах зээлийн эдийн засагт шилжсэний дараа байгалийн гамшиг, нийгмийн асуудлыг шийдвэрлэх малчидын философи ба хамтлага

Имаока Риоко

(要約)

ネグデル体制下の遊牧民が望んでいたことは、五畜の主人公になり、伝統的な遊牧共同体(ホタイル)を復活させ、自然と調和した社会を取り戻したいということであった。果たして、市場経済への移行により、その望みはかなったのだろうか?この視点から移行後の遊牧社会の問題を問い直す必要がある。


ネグデル解体後、確かに私有家畜にもとづく家族経営とホタイルは復活し、遊牧民は意欲的に飼養頭数を増やした。しかし、2000年から2001年にかけての寒波によってゾド(家畜の大量死)がおり、ネグデル解体前の飼養頭数に戻った。モンゴル政府は、選挙のたびに政権交代してきたが、どの政権も農政について無策であり、ネグデルに代わる組織を再構築しなかった責任は大きい。

一方、遊牧民自身は独自の努力を重ねてきた。バヤンホンゴル県ツエルゲルにおいては、伝統的な遊牧共同体社会をネグデルに代わる組織ホルショーに発展させ、市場経済の競争原理から地域社会を守ろうという取り組みが行われた。しかし、政府がさらなる自由化を推進したため、小さな協同組合は市場の波に飲み込まれてしまった。また、遊牧民の意識の中にも競争原理や拝金主義が浸透してきた。カシミヤ価格の急騰により物欲をかきたてられ、急落により家畜を手離す牧民が増えている。

ルールなき資本主義の下、自然災害や身内の不幸をきっかけに没落する牧民は増え続けているが、ごく少数ながら動じない牧民もいる。遊牧民ダンバは家畜と気象と草地を徹底して観察し、適宜労働を投入することにより、自然災害や市場の波を乗り越え、家畜を安定的に増やしてきた。これは、農業切り捨て農政の下、生き残ってきた日本の農家が、安易な近代化や経営の効率化、利潤追求主義に走らず、自然に謙虚に学ぶことにより農業経営を確立し、維持してきたこと、例えば日本の山地酪農家斎藤晶の蹄耕法の思想に通じるものがある。遊牧民は農(遊牧)と共生の論理に今一度立ち戻ること、政府はそれを支持し、資本の論理から農牧業を守ること、今大切なことだと思われる。

(0) Малчид байгальтайгаа зохицсон уламжлалт нүүдэлчдийн хамтлагийг хүсч байсан боло вч

Зураг 1-ээс харахад, малын тоо толгой 1982 оноос буурч, нэгдлийн үед түрээсийн тогтолцоо хэрэгжүүлсэн 1988 оноос өсч, 1992 онд нэгдэл тарсаны



Зураг 1-д Баянхонгор аймгийн малын тоо толгойн өөрчлөлтийг тусгав.


Баянхонгор аймгийн малын тоо толгойн өөрчлөлт.¹

дараа дахин нэмэгдсэн байна. Гэвч 1999 оноос малын тоо 1990 оны түвшинд хүртлээ хорогджээ.

1992 оноос хувийн өмчид тулгуурласан ардын аж ахуйтан, төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн чөлөөт эдийн засагт шилжсэнээр малаа өсгөж чаджээ. Гэвч нийтээрээ байгалийн гамшигийг давах нөхцөл бүрдээгүйгээс малын тоо толгой буурч ирснийг зураг 1-ээс харж болно.

Монголын засгийн газар зах зээлийн эдийн засагт шилжсэний дараа нэгдлийн оронд хоршоо үүсгэх, дахин зохион байгуулах бодлого авч хэрэгжүүлээгүй. Зарим газар малчид өөрсдөө хоршоо байгуулж байлаа. Тэд алдаж оносоор бүс нутгийнхаа байгаль, нийгмийн нөхцөлд тохирсон ардчилсан хоршоо байгуулсан ба засгийн газрын зүгээс дэмжих бодлого хэрэгтэй гэж бодож байна.

Зураг 2-оос харахад 1993 оноос Баянхонгор аймгийн ямааны тоо толгой хониноос давжээ. Миний бие 1989 оноос Баянхонгор аймгийн нийгмийн асуудлын талаар судалгаа хийж ирсэн бөгөөд 1989-1992 онд явуулсан асуулгаас харахад малчид, нэг өрх гэр нэг төрлийн мал маллах гэхээсээ хот айлаар хамтарч таван хошуу мал маллан, бэлчээрээ нарийн хуваарьтай ашиглаж, ашиг шимийг хаягдалгүй авахыг зорьж байна. Тэгээд нүүдэлчдийн уламжлалт боломжийн хамтлагийг дахин сэргээх санал давамгайлж байлаа(Имаока



Зураг 2 Баянхонгор аймгийн таван хошуу малын тоо толгойн өөрчлөлт.²

1993,1999,2002)³. Зураг 2-т үзүүлж байгааг зах зээлийн эдийн засагт шилжсэний дараа малчид ямаа олноор үржүүлэх болсон байна. Үүний шалтгааныг хүснэгт 1-ээр үзүүлэв.

Өөрөөр хэлбэл, 1993 оны үеэс малчид ямааны ноолуурыг олон улсын хэмжээнд мөрдөж буй өндөр үнэ ханшаар зарж, говийн малчдын хувьд бэлэн мөнгөний орлогоо нэмэгдүүлэх баялагийн эх булаг болов. Засгийн газар мал аж ахуйн бүтээгдэхүүний үнэд хяналт тавилгүй, зах зээлд найдаж орхисноор мал аж ахуйн бүтээгдэхүүн эрхлэгчид нэг төрлийн мал дагнан хариулж, аж ахуй эрхлэлт өргөжив. Чингэснээр бэлчээрийн асуудал улам газар авах болов уу.

Энэ мэтчилэн нэгдэл тарсны дараа байгалийн гамшгийг даван гарах нийгмийн нөхцөл байхгүй болж, малчид малгүй хохирогч болох, мөн малчид өөрсдөө нэг төрлийн мал олноор маллах болсноор байгалийн экологийн

Хүснэгт 1. Баянхонгор аймгийн ноос ноолуурын үнийн өөрчлөлт

	1990он	1993он	2001он
ноолуур	36	1200~1500	27300
ноос		70	630
тэмээний эм ноос		130	1970

Нэгж: төгрөг/кг, Баянхонгор аймагт явуулсан асуулгад тулгуурлав.

Зах зээлийн эдийн засагт шилжсэний дараа байгалийн гамшиг, нийгмийн асуудлыг шийдвэрлэх малчдын философи ба хамтлага

тэнцвэртэй байдал алдагдахад хүрээд байна. Өнөөдрийг хүртэл хийсэн судалгаа, асуулгадаа үндэслэн тэмдэглэхэд малчид үүнийг хүсээгүй. Харин ч байгальтайгаа зохицсон уламжлалт нүүдэлчдийн хамтлагийг хүсч байсан юм. Ийм бодол санаатай малчид хамтарсан нь цөөнгүй (Имаока,1993). Тэд хүссэн нийгмээ яаж дахин байгуулах бол, миний бие Баянхонгор аймгийн Богд сумын жишээн дээр авч үзье гэж бодож байна.


(1) Хоршооны тухай: 1992 онд, Баянхонгор аймгийн Богд сумын Цэлгэрт байгуулсан ардын аж ахуйтны "Үүрийн туяа" хоршооны жишээнээс

Баянхонгор аймгийн Богд сум Улаанбаатараас баруун зүг 740 км зайтай, 3983 хавтгай дөрвөлжин км газар нутагтай, хэмжээгээрээ Токио хотоос 1.8 дахин уудам. 2000 оны байдлаар 3226 хүн амтай, 113338 толгой малтай, үүнээс 70128-ыг ямаа эзэлдэг.⁴

Богд сумын өмнө талд Алтайн нурууны төгсгөл болох 3000 метр өндөр мөнх цаст Богд уул говь нутагт сүндэрлэн байдаг. Түүний зүүн үзүүрт, сумын төвөөс



Зураг 3 Баянхонгор аймгийн Богд сум



Зураг 4 Богд сумын 4-р баг Цэлгэр

70 км алслагдсан газар Зүүн Богдын уулархаг говийн бүсэд Цэлгэр оршдог.

Цэлгэрийн малчид 1991 онд нэгдлээс гарсны дараа жил 1992 онд "Үүрийн туяа" хоршоо байгуулсан байна. Хурлаар хэлэлцсэн хоршооны дүрмийг танилцуулъя. Дүрмэнд байгалийн гамшиг, капитализмын зарчмаар сул доройгоо хүчтэй нь иддэг нийгмийг даван гарч, байгальтай зохицон уламжлалт хамтлаг байгуулах гэсэн сэтгэлгээ, санал бодол тусчээ.

(1.1) "Баянхонгор аймгийн Богд сумын 4-р багийн ардын аж ахуйтны "Үүрийн туяа" хоршооны дүрэм"

"Үүрийн туяа" ардын аж ахуйтны хоршоо нь бие даасан ардын аж ахуйтан болон орон нутгийн бусад хүмүүсийн сайн дурын санаачлагаар нэгдэн байгуулсан аж ахуйн нэгж болно.

Хоршоо нь нүүдлийн мал аж ахуйн уламжлалд түшиглэн хамтын хүчээр өөрсдийн амьдрал ахуйг дээшлүүлэх, нутаг орны бие даасан байдлыг бий болгож, хөгжүүлэхийг зорино. Үүний тулд ардын уламжлалт зан үйл, гар урлалыг сэргээж түүнд түшиглэн шинжлэх ухааны ололтыг зүй зохистой нэвтрүүлэн, мал аж ахуйн болон орон нутгийн байгалийн нөөц бололцоог бүрэн дүүрэн ашиглаж, төрөл бүрийн хагас болон бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь чухал юм.

Хоршооны туйлын зорилго бол үйлдвэрлэлийг хөгжүүлж түүнд түшиглэн аз жаргалтай амьдралыг бий болгоход оршино. Тиймээс ч хоршоо үйлдвэрлэлийн хүрээнд ажиллах төдийгүй эрүүл мэнд, боловсрол, соёл урлаг, спорт зэрэг амьдралын бүх хүрээг хамарч хөгжүүлэхийн тулд шаардагдах нөхцөлийг бий болгоно. Үүний үр дүнд бий болсон орчинд хүний олон талын бүтээлч үйл ажиллагаа баталгаажиж, авъяас чадвараа чөлөөтэй хөгжүүлж чадна. Хүн амьдрах чухал орчин болох орон нутаг энэ бүх хүчин чармайлтын ачаар сая оршин суугчдын төлөө үйлчлэх газар болох юм.

Хоршоо дээрх зорилго дор өөрсдийн амьдралаа дээшлүүлэхийн зэрэгцээ орон нутгаа хөгжүүлэхийн төлөө өөрийн үүргээ ухаарч, хоршооны гишүүн бус хувь хүн, гэр бүл, байгууллага хамт олон, орон нутгийн захиргаатай хамтран ажиллаж, хамтдаа орон нутгаа хөгжүүлэхийг зорино. (1992)

Энд өгүүлсэн үгийг гаднаас зээлээгүй, зорилгоо хуулбарлаагүй. Цэлгэрийн малчдын өдөр тутмын амьдралаас урган гарсан хамтын оюун санаа хийгээд бахархамаар үндсэн хууль гэж болно. Мөн зах зээлийн эдийн засгийн шинэ "өмнөд"-ийн ертөнцөөс салах, улмаар орон нутгаа шинээр цогцлон байгуулах тунхаглал болжээ.

Монголын малчид урт түүхийн явцад анх удаа үйлдвэрлэл, амьдралынхаа

Зах зээлийн эдийн засагт шилжсэний дараа байгалийн гамшиг, нийгмийн асуудлыг шийдвэрлэх малчидын философи ба хамтлага

жинхэнэ эзэн нь болох үеэ утглаа гэдэг утгаар хоршоогоо "Үүрийн туяа" хэмээн нэрлэсэн байна.

(1.2) Хоршооны үйл ажиллагааны зорилго.

Хоршоо дүрмийнхээ дагуу дор дурьдсан зүйлийг үйл ажиллагааныхаа зорилго болгожээ.

(1.2.1) Хоршооны дотоодод ардчилал, ардчилсан тогтолцоог бий болгоно.

- а) Удирдлага, зохион байгуулалтын асуудал
- б) Хоршоо дотооддоо сайн дурын үүсгэл санаачлагаар бий болсон хамтын хэлбэрийг бүх талаар дэмжинэ.

(1.2.2) Мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар

- а) мал эрүүлжүүлэх
- б) худаг, хашаа хороо, тэжээл зэрэг
- в) байгалийн бэрхшээлтэй тэмцэх

(1.2.3) Байгаль, мал аж ахуйн түүхий эдийг бүрэн дүүрэн ашиглах талаар

- а) ноос угаах, будах, ээрэх, нэхэх, эсгий хийх
- б) оёдол, хатгамал, гутал хийх
- в) мужаан, дархан(алт, мөнгө)
- г) арьс шир элдэх
- д) эмийн ургамал, гэрэлтүүлэг зэрэг байгалийн нөөцийг ашиглах

(1.2.4) Бүтээгдэхүүн борлуулах, үйлдвэрлэл, өргөн хэрэглээний бараа таваар нийлүүлэх, түүнийг боловсронгуй болгох талаар

(1.2.5) Хоршооны тээвэр эрхлэлтийг сайжруулах талаар

- б) Ахуй амьдралыг дээшлүүлэх талаар
- а) гэрэл цахилгаан, холбоо харилцаа, гэрийн нөхцөлийг сайжруулах зэрэг

(1.2.6) бодит туслалцаа үзүүлэх

(1.2.7) Хүнийг бүхий л талаар хөгжүүлэх соёлын үйл ажиллагаа

(1.2.8) Орон нутгийн иж бүрэн хөгжилд анхаарч, засаг захиргааны дэмжлэг тусламжтайгаар боловсрол, соёл, эмнэлгийн салбарыг бэхжүүлэнэ.

- а) сургууль байгуулах
- б) эмнэлгийн салбар байгуулах
- в) соёлын төв байгуулах
- г) зам, тээврийн хэрэгслийг сайжруулах

(1.2.9) Аймаг, сум, орон нутгийн ирээдүйн хөгжлийн бодлогод хувь нэмрээ оруулана.

(1.2.10) Гадаадын улс оронтой холбоо харилцаа тогтооно.

- а) сайн санааны харилцаа

б) худалдааны харилцаа

в) аялал жуучлал

Энэ үйл ажиллагааныхаа зорилгод, нэгдлийн зөв зүйтэй зүйлийг хоршоо уламжлан авах, нэгдлийн үед алдсан зүйлээ эргүүлж бий болгох, зах зээлийн эдийн засгийн үед хэрэгжүүлэх шинэ бодлого ч орж байгаа болно. Хоёр дахь хурлаар эхний хурлаар хэрэгжүүлэхээр заасан (3) мал аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах, (4) өргөн хэрэглээний бараа таваар нийлүүлэх, (8) салбар сургууль байгуулах тухайд үр дүнг мэдээлэв.

(1. 3)Хоршоо тарсан нь

Хоршоо байгуулагдсаны дараа 2 жил болоод, 1995 онд очиход Цэлгэрийн хоршооны хүчин чадал буурсан байлаа. Мөн оны 1-р сарын бүх гишүүдийн хурлаар хоршоо тарах асуудал хэлэлцэж, Цэлгэрийг дуурайж байгуулсан сумын хоршоодын үйл ажиллагаа аяндаа замхарчээ. Цэлгэрийн жижиг хоршоо зах зээлийн эдийн засгийн давалгаанд автсан шалтгаан нь дараах 3 хүчин зүйлтэй холбоотой болов уу.

Нэгдүгээрт, ноолуурын үнэ хадсан явдал юм. 1992 онд нэгдлийн худалдан авдаг ноолуурын үнэ 1 килограмм нь 190 төгрөг5 байв. Хоршооны худалдан авдаг үнэ 1993 онд 1200 төгрөг, 1995 онд 12000 төгрөг болсон байна. Энэ нь тухайн үеийн ханшнаас бага зэрэг үнэтэй бөгөөд нэгдлийн үетэй харьцуулахад бараг 100 дахин өсчээ.

Хоёрдугаарт, Наймаачид ирж очих нь нэмэгдсэн байна. Ноолуур олон улсын зах зээлийн үнээр арилжаалагддаг цорын ганц мал аж ахуйн бүтээгдэхүүн юм. Гэрийнх нь өмнө машинаа зогсоож, гурил, цай зэрэг өргөн хэрэглээний бараанаас өгсүүлээд орчин үеийн хувцас, мотоцикль, нарны зайгаар ажилладаг гэрэл зэрэг тансаг бүтээгдэхүүн хүртэл төрөл бүрийн барааг малчдад дэлгэн харуулж байжээ. Ноолуурын үе 5-р сарын эхээр наймаачид өдөрт 5, 6 удаа ар араасаа ирж байсан гэдэг. Хоршоо ноолуурын гол газрыг булаахаар ирсэн "царцааны их сүрэг"-т дийлэгдэв.

Гуравдугаарт, малын тоо толгой нэмэгдснээр орлого өссөн байна. Цэлгэрийн малчид хувийн малаа өсгөхөд л анхаарч байжээ. Нэгдлийн үед нэг малчин өрхөд дунджаар 50 толгой мал ногдож байсан бол 1995 онд өсч, 185 толгой болсон аж. 88 өрхийн дотор 300-гаас дээш малтай өрх 10, 600-гаас дээш малтай 2 ч өрх бий болсон байна. Ялангуяа ямаа өсч, 1 малчин өрхөд дунджаар 120 толгой ногдож, түүнээс унах жилийн орлого ойролцоогоор 809 доллар, албан хаагчийн жилийн орлого 480 доллороос бараг 2 дахин их гэж болно. Орлого нь нэмэгдсэн малчид янз бүрийн юм худалдаж авах болсон байна. Жишээлбэл, 15

килограмм ноолуураар(45 ямаа) хятадад үйлдвэрлэсэн салхины хүчээр ажилладаг цахилгаан үүсгүүр, 50 килограмм ноолуураар(150 ямаа) мотоцикл худалдан авдаг байна. Тиймээс малын тоо толгойг нэмэгдүүлэхэд гойд анхаарч байжээ.(Имаока, 1995 оны судалгаа) Социализмын үед ядуу нэртэй байсан говийн малчид одоо өөрийн хүчээр ямаагаа өсгөж, амьдралаа сайжруулж хангалуун амьдрах болов.

Энэ мэтчилэн ноолуурын үнэ хадаж, наймаачид байнга ирж очиж, малын тоо толгой нэмэгдснээр орлого нэмэгдэж, үүнээс үүдэн малчин өрхийн сонирхол хамтыг гэхээсээ хувьдаа илүү анхаарах болсон байна.

Гэхдээ бүх гишүүдийн хурлаар салбар сургуулийг тэтгэхийн тулд хоршоо хэрэгтэй гэдгийг зөвшөөрч, хоршоог тараалгүй байлгахаар тогтжээ.

Түүний дараа 1999 онд малчид эсэргүүцсэн хэдий ч салбар сургуулийг хаахаар болж, хоршоо тарсан байна⁶.

Засгийн газар мал аж ахуйн бүтээгдэхүүний дээд доод үнэд хязгаар тогтоож, мал аж ахуйн бүтээгдэхүүний арилжааг улс мэддэг болох зэрэг зах зээлийн эдийн засагт зохицсон хязгаарлалт хийх явдал япон, европ америк зэрэг улс оронд байдаг зүйл юм. Ерөнхий сайд Жасрай хоршоог дэмжиж, хоршооны дүрэм "Ардын эрх" сонинд хэвлэгдэв. Үүнээс өөрөөр хоршоог дэмжих бодлого явуулаагүй. Сүүлийн 10 жил Монголын засгийн газар зах зээлийн эдийн засагт зохих хязгаар тавьж байсан бол нэгдлийн оронд гарч ирсэн "Үүрийн туяа" хоршоо үйл ажиллагаагаа үргэлжлүүлж, өсч өндийн байгалийн гамшгийг даван гарах чадалтай болсон байхыг үгүйсгэхгүй.

(2) Малчдын философи

(2.1) Баянхонгор аймгийн Цэлгэрийн малчдын нийгмийн асуудал

Хоршоо тарсны дараа малчид ямаа маллаж тоо толгойг нэмэгдүүлснээр нийгмийн янз бүрийн асуудлаа шийдсээр ирсэн. Гэвч шийдэж чадахгүй асуудал ч гарч ирэв. 2001 оны судалгаанд тулгуурлан Цэлгэрийн малчдад тулгарсан 4 асууасуудлыг танилцуулъя⁷.

(2.1.1) Хар зуд

Богд суманд 2000 оны зун 2 жил дараалан ган болж, мал тарга хүч авч чадалгүй өвөлтэй золгож, 2001 оны хавар хар зуд болов. Мал шороон шуурганд нүдүүлж, бэлчээр талхлагдаж, цасан шуурга шуурч, 26000 мал үхснээс хавар төллөсөн нялх төл 50 хувийг эзэлж байна.

(2.1.2) Ноолуурын үнийн өөрчлөлт

2000 онд ноолуурын үнэ 40000 төгрөг хүрч, малчид "баян" болж говь нутагт машингүй хүн байхгүй гэхээр болов. Гэвч 2001 онд 26000 төгрөг хүртлээ буурч,

зээлээр өндөр үнэтэй бараа худалдаж авсан малчид малаасаа салж эхлэв.

(2.1.3) Малгүй болсон нь

Цэлгэрийн настайчууд "машинтай болохоор малдаа анхаарал тавихаа больж, малчин биш болов" гэж ярьж байлаа. Өөрөөр хэлбэл, сум, аймаг, Улаанбаатар орохын тулд хүүхдээрээ малаа хариулуулж, өөрөө малаасаа хөндийрдөг. Мөн өвөл цаг агаар хүндрэх төлөвтэй болбол намар нь малаа зарж, тэр мөнгөөрөө хавар нь дахин малтай болно гэж боддог гэсэн үг юм.

Мөн настайчууд, "нэгдлийн үед мал нийгмийн өмч байсан. Тийм болохоор малаа үхүүлэхгүй гэж уламжлалт арга ухаан, шинжлэх ухааны технологийг хэрэглэж, малаа авч гарч байлаа. Одоо мал хувийнх болсон учраас малаа хайрлахаа больжээ" гэж ч хэлж байлаа. Жишээлбэл, малаа зоосны нүхээр харж, 1 хонь үхүүлбэл 10000 төгрөг алдлаа гэх болжээ. Алдсан мөнгөө наймаагаар нөхнөө гэж тооцоолох болсон байна. Ингэснээр хохирол улам нэмэгддэг.

(2.1.4) "Төмрийн зуд"

Шороон шуурганаар ч малаа оторлож, малаа эсэн мэнд авч гарсан настан "төмрийн зуд" бий боллоо гэж ярьж байна. "Төмрийн зуд" гэдэг нь бензин, засварын зардлаа бодолгүй машин худалдан авч, малаа зарсаар өмч хөрөнгө нимгэрч, машин хөдлөхөө больж, төмрийн хог болж, малчин бүхнээ барахад хүрдэгийг хэлж буй хэрэг.

Энэ мэтчилэн Улаанбаатараас 800 гаруй километр алслагдсан уулархаг говийн бүс нутагт малчдын сэтгэл санаа өөрчлөгдөж мөнгө шүтэж, байгаль малаа гэхийн оронд мөнгө олох арга сүвэгчилэх малчдын тоо өссөөр байна. Дээр өгүүлсэнчлэн капитализм нь малчдыг байгалиас төдийгүй малчдын нэг нэгэндээ тусалдаг харилцааг өөрчилж зөвхөн хувиа бодоход хүргэж байна. Гэтэл настайчууд "малчин хүн бол тэнгэрээ харж, цаг агаараа шинжиж, нутаг бэлчээрээ сонгож, малаа ажиж, тарга тэвээр авахуулдаг. Нутаг орондоо тохирсон мал маллах нь мөнгө тоолохтой адил амар ажил биш" гээд байгальтай улам нарийн харьцах хэрэгтэйг өгүүлж байна. (Имаока, 2001)

(2.2) Байгаль, зах зээлийн шалгарлыг даван туулсан малчин Дамбын "алдаагүй 10 жил"

Дамба Цэлгэрийн жинхэнэ малчдын нэг гэгддэг тэргүүний малчин, ануухан 50-иад настай. Түүний бодол, үйл ажиллагааг танилцуулъя.

(2.2.1) Малын ашиг шимийг нэмэгдүүлэх

Дамба нэгдэл тарсны дараа Сүхбаатар аймгаас сайн үүлдрийн ямаа оруулж, 10 жил заран байж, бие томтой ямаатай болсон байна. Цэлгэрт 1 ямаанаас дунджаар 330 грамм ноолуур, том эр ямаанаас 500 грамм ноолуур авдаг.

Дамбын хариулдаг 1 ямаанаас дунджаар 500 грамм, эр ямаанаас 1 килограмм ноолуур гардаг гэсэн. Дамба ноолуурын үнэ унасан ч малынхаа өндөр ашиг шимээр нөхөж чадсан байна.

(2.2.2) Байгалиа шинжих

2001 оны зун Цэлгэрийн малчид өвлийг өнөтэй давахын тулд хадлан авах бодолтой байсан бол Дамба өөр байлаа. Тэрээр хадлан авахгүй, боодол нь 3000 төгрөг хүрдэг үнэтэй гэжээл авахгүй, түүний оронд малаа өөрөө хариулж, өсгөх арга ухаан өвөрлөж байсан байна. Тухайлбал, малаа бэлчээрлүүлж хөлсөлсний дараа хужиртай газар луу туудаг. Хонь ямаагаа уулын оройгоор хариулдаг. Бороотой үед, малаа уулын бэлийн элсэрхэг газар бэлчээрлүүлж, таана идүүлдэг. Энэ мэтчилэн цаг агаарын өөрчлөлтөнд тохируулж бэлчээр сонгон, малаа хариулдагаас Дамбын мал тарга хүч сайн авдаг байна. Зун тарга хүч сайн авахуулдагаас өвлийг хохиролгүй давдаг гэж нутгийнхан үнэлдэг.

1990-ээд оныг японд ч, хуучин социалист оронд ч "алдагдсан 10 жил" гэж хэлдэг боловч малын ашиг шимийг дээшлүүлж, цаг агаар, бэлчээр, малаас нүдээ салгалгүй амьдарч ирсэн Дамбын хувьд "хуримтлуулсан 10 жил" байсан бололтой. 1990 онд 120 толгой малтай байсан бол түүнийгээ өсгөж, хүүхдүүддээ ч өмч хуваан өгөөд, 800 толгой малын эзэн болоод байна. Хоёр хүргэндээ нэг нэг шинэ жийп худалдаж авч өгсөн нь "төмрийн хог" болоогүй аж. Хэдийгээр баян болсон ч сэтгэл санаа нь түүнд хөтлөгддөөгүй явдал Дамба малаа гэсээр ирсэнтэй холбоотой .

Мөн Дамба шиг мал маллах арга ухаантай малчид байгалийн гамшгийг давж, Цэлгэрт хоршоо дахин байгуулах хэрэгтэй гэж ярьж байгаа нь анхаарал татаж байна.(Имаока, 2002)

(2.3) Байгаль, зах зээлийн шалгарлыг давж буй японы уулын малчин*

Дамбын яриаг сонссоны дараа, миний бие Хоккайдоогийн Асахикава хотын уулын тариачин Сайтоо Акираг санаж билээ.

Дайны дараа Японы засгийн газар улсын фонд, дэлхийн банкнаас зээл авч, Хоккайдоог европ америк маягийн орчин үеийн том хөдөө аж ахуйн бүс болгохоор өөрчлөн байгуулсан. Бульдозороор бэлчээр гаргаж, малын том байр, тэжээлийн агуулах барьж, орчин үеийн суурин үхрийн аж ахуйгаараа нэртэй газар болсон юм. Гэвч хөдөө аж ахуйн хоршооллоор дамжуулан зээл авч, тэр өрөө барагдуулж чадалгүй, хөдөө аж ахуйгаас салахад хүрсэн тариачин, малчин өрх ар араасаа дампуурсаар байна.

Сайтоо Акирагийн аж ахуй эрхлэх арга нь техникээр бэлчээр гаргалгүй байгалийн бэлчээрт үхрээ идээшлүүлж, түүнийг ажиглах явдал байлаа.

Жишээлбэл, малын хашаа 30 мянгаас 40 сая иен бөгөөд Сайтоо үхрийн биеэс ялгарах дулаанд тулгуурлан халуунаа хадгалах боломжтой нийлэг эдлэлээр малын байр барьж, мөн хэдэн түмэн иений үнэтэй тэжээлийн агуулах хямд төсөр нийлэг эдлэлээр босгосон байна. Даршилсан тэжээлд тулгуурлалгүй бэлчээрийн мал аж ахуй бий болгохын тулд том тэжээлийн агуулах худалдаж авах шаардлагагүй байжээ.

Хоккайдоогийн 1 үнээнээс (holstein) жилд дунджаар 7366 литр⁹ сүү гардаг, тэжээл их өгвөл 20 мянган литр сүү гардаг үнээ ч байдаг. Гэвч Сайтоогийнх 1 үнээнээс жилд 3600 литр сүү авдаг¹⁰ ч тэжээлийн зардлаа багасгаж, сүүнийхээ хэмжээг 3000 литр болгох бодолтой байгаа юм байна. Үйлдвэрлэлээ багасгасан ч зардлаа хорогдуулбал аж ахуйгаа бүрэн авч явах боломжтой гэж үзжээ.

Үхрээ бэлчээрлүүлж, сүү шимийг нь авдаг. Энэ бол жинхэнэ мал аж ахуй гэж Сайтоо үзэж байна. Энэ л зах зээлийн эдийн засагтай японы хувьд сүүний аж ахуй дампуурахгүй байх арга ажээ. 2002 оны 6-р сард очиход том хэмжээтэй, механикжсан үйлдвэрлэлийн үр ашигийг чухалчилж, ашиг хөөж дампуурсан суурин аж ахуйгаас бэлчээрийн мал аж ахуйд шилжих нь зүйтэй юм байна гэж бодоход хүрсэн малчид Сайтоогийнд ирж түүний аж ахуйтай танилцаж байв. Мөн хэд хэдэн айл өөрийн бэлчээр малаа нийлүүлж, хамтын өмчинд тулгуурласан хөдөө аж ахуйн хоршоо байгуулахаар сэдэж, Сайтоогийн аж ахуйтай танилцахаар очсон байлаа.

Дамба, Сайтоогийн нийтлэг тал бол байгалийн нөөцийг дээд хэмжээгээр ашиглахын тулд байгалиа уйгагүй ажиглаж, өөр өөрсдийн бүс нутгийн байгалийн нөхцөлд тохирсон мал маллагааны арга барилтай болох гэсэн бодол юм. Тэдэн шиг байгальтайгаа зохицсон мал маллах тэргүүний арга ажиллагаатай ардын аж ахуйтан, тэдний байгуулсан хоршоог засгийн газар дэмжсэн бодлого хэрэгжүүлбэл хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчид хүсч буй байгальтай зохицсон бүс нутгийн нийгмийг дахин байгуулж чадна бодож байна.

(3) Төгсгөлийн оронд

Цаашид Монголд цаг агаарын өөрчлөлт, цөлжилт зэрэг экологийн өөрчлөлтөнд тохируулан амьдарч чадах нь тогтолцоо өөрчлөгдсөний дараа 10 жил малаасаа нүд салгалгүй амьдарч ирсэн малчин л болов уу. Гэвч газар улсын өмчинд байхад капиталист тогтолцоо төгс хэрэгжихгүй болохоор хэзээ нэг цагт хувьчлагдах болов уу. Хэрэв бэлчээрийг хувьчилбал малчид байгалийн нөөцийг ашиглах чавдараа алдаж, түүгээр үл барам зөвхөн өвсөөр хүнсээ хангах тэрчлэн үндэсний соёлоо хамгаалахад ч хэцүү болно. Мэдээж газрын асуудал бол монголчуудын шийдэх асуудал билээ. Монголчууд бэлчээр эзэмших асуудлыг шийдэхдээ Манж Чин улсын

үеийн түүхийг сөхөж, мөн Өвөр монголын одоогийн байдалтай танилцаж, ухаалаг зөв сонголт хийнэ байх гэдэгт итгэж байна.

-
- 1 National Statistical Office of Mongolia,"Agriculture in Mongolia 1971-1995",UB,1996., "Mongolian Statistical YearBook"1996-2001,UB,1996-2001
 - 2 National Statistical Office of Mongolia,"Agriculture in Mongolia 1971-1995",UB,1996., "Mongolian Statistical YearBook"1996-2001,UB,1996-2001
 - 3 Имаока Рёоко. Малчдын ардчилал ба бүс нутгийг хөгжүүлэх онол, "Монгол судлал"№15,1993. 1989 он "Эдийн засгийн шинэчлэл"-ийн үеийн нэгдэл, "Монгол судлал"№17, 1999. "Говь нутагт хамтын тогтолцоог эрэлхийлэх нь-Монголын өмнөд ертөнцөөс", "Өмнөдөөс харсан ертөнц 01", 1999. "Судалгааны дэвтэр-1990 он, Баянхонгор аймагт хийсэн судалгаа" 2002, "Оосакагийн Гадаад Судлалын Их Сургуулийн эмхтгэл", 2002.
 - 4 2001 он, Богд сумаас авсан материал
 - 5 Нэгдлийн үед 1 доллар 3 төгрөгтэй тэнцэж байв.
 - 6 Имаока Рёоко, "2001 оны зуны монголын судалгааны дэвтэр", Санкэйшя,2002 он.
 - 7 Имаока Рёоко, "2001 оны зуны Цэлгэр-Малчдын сэтгэлгээнд нэвтэрсэн капитализм", "Монгол судлал", №19, 2002.
 - 8 Сайтоо Акира,"Үхрээр гишгүүлж гаргасан бэлчээр", Жиюүшя, 1989.
 - 9 2000 оны мэдээ, Хөдөө аж ахуйн яам, 2001 он
 - 10 2001 оны мэдээ, Митана Кацүносүкэгийн судалгаагаар.

(2002. 10. 4 受理)